



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/548

Есөнбулаг

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4 дэх заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 35 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оросын Холбооны Улсын Москва хотын Бауманы нэрэмжит Техникийн их сургуульд суралцаж буй Энхболдын Цээноров болон Москва хотын Сеченовын нэрэмжит Анагаах ухааны их сургуульд хүний их эмч мэргэжлээр суралцаж буй Энхболдын Цээсүрэн нарын гаргасан хүсэлтийг үндэслэн замын зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР